



MOORE

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
2023 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр тасалбар болгосон
Санхүүгийн тайлангийн аудит

Улаанбаатар 2024

АГУУЛГА

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ.....	
БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....	
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	1-5
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	7
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	8
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10-34
1. Ерөнхий мэдээлэл	10
2. Үйл ажиллагааны тасралтгүй зарчим.....	11
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.1 Тайлан бэлтгэх үндэслэл.....	11
3.2. Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд.....	12
3.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбарууд.....	13
3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй	13-17
4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага	17
4.1 Зах зээлийн эрсдэл.....	18-19
4.2 Хөрвөх чадварын эрсдэл	20
4.3 Зээлийн эрсдэл.....	20-22
4.4 Капиталын эрсдэлийн удирдлага.....	22
5. Бодит үнэ цэний хэмжилт	23-24
6. Ашигласан гол тооцоолол ба мэргэжлийн шийдлүүд.....	24
7. Хүүгийн орлого.....	25
8. Ногдол ашгийн орлого	25
9. Санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарз	25
10. Бусад олз (гарз)	26
11. Сангийн үйл ажиллагааны зардал	26
12. Орлогын татвар	26
13. Санхүүгийн хөрөнгүүд.....	27-30
14. Хүүгийн авлагা.....	30
15. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	30
16. Сангийн нэгж эрх.....	30
17. Бусад нөөц.....	30

18. Хуримтлагдсан ашиг (алдагдал).....	31
19. Бусад өглөг.....	31
20. Орлогын албан татварын өр	31
21. Хойшлогдсон татварын өр	31
22. Холбоотой талууд.....	32
23. Хууль, дүрэм журмын нийцэл	33
24. Болзошгүй өр төлбөр.....	33-34
25. Тайлагналын дараах үйл явдлууд	34

Мандал Ирээдүйн Өсөлт
Хамтын Хос ХХК

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамыян гүний гудамж, Меру тауэр, 602 тоот
Шуудангийн хайрцаг – 2292,
Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7272 9911

2024.03.15 № 24/031

-ны №

МҮҮГЬ АУДИТ ХХК-д

Удирдлагын хариуцлагын мэдээдэл

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХОС ХХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн удирдлагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Г. ГАНЗОРИГ

Г. ГАНЗОРИГ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н. УРАНГУА

ЕРОНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан ХХК нь 2021.05.18-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны 2021.08.18-ны өдрийн 328 дугаар тогтоолоор Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг 10 жилийн хугацаатай эрхлэхийг зөвшөөрсөн.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 901182609, байгууллагын регистрийн дугаар 6702988. Тусгай зөвшөөрлийн дугаар ТЗ 312/02.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүд

ТУЗ-ийн дарга Р.Амаржаргал
ТУЗ-ийн гишүүн Н.Монсор
ТУЗ-ийн гишүүн Г.Батзориг
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Анхбаяр
ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Батсүх
Монгол улсын иргэн Ганбат овогтой Ганзориг.

Хөрөнгө оруулалтын
менежментийн компани

"Мандал Ассет Менежмент УЦК" ХХК

Бүртгэлтэй бирж

"Монголын хөрөнгийн бирж" ХК

Кастодиан банк

"Голомт Банк" ХХК-ийн кастодиан үйлчилгээний хэлтэс

Бүртгэлтэй хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүний гудамж, Меру Тауэр 602 тоот.

Аудиторууд

"Мүүрь Аудит" ХХК

Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Тайлан

Дүгнэлт

Бид, "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан" ХХК-ийн (цаашид Сан гэх) 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийллээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Сангийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагнналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу сангаас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн их ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба эдгээр асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй. Бид дараах асуудлыг гол асуудал гэж тодорхойлсон.

Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэний хэмжилт

Сангийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан дахь бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдэд Монголын Хөрөнгийн биржээр арилжаалагддаг өрийн болон өмчийн хэрэглүүр багтсан. Бид аудитын явцад удирдлагын үнэлэмжээр санхүүгийн хөрөнгүүдэд ашигласан тооцоолол, мэргэжлийн шийдлийг үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд ирээдүйд тохиолдох нэг болон хэд хэдэн үйл явдлын үр дүнд эдгээр тооцоолол төсөөлөл нь өөрчлөгджэй болзошгүй юм.

Асуудлыг онцгойлох зүйл

Бид тодруулга 24 Болзошгүй өр төлбөр-т анхаарал хандуулсан.

Сан нь нэгж эрхийг Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхэд төлөх үйлчилгээний хөлстэй холбоотой зарга маргаан үүсгэсэн нь 2023 оны 12 сарын 31-ний байдлаар үргэлжилж байгаа учир Монголын хөрөнгийн бирж ХК-ийн нэхэмжилж байгаа үйлчилгээний төлбөрийг бүртгээгүй.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Сангийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу сангийн үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах чадамжийг үнэлэх, боломжтой бол

тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, няглан бodoх бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Сангийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохиорохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Сангийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохиорохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан няглан бodoх бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, няглан бodoх бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Няглан бodoх бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай

холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитаар илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад мэдээлэл


Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт гаргаагүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор аудитор нь бусад мэдээллийг уншиж танилцан, уг бусад мэдээлэл нь аудитласан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотой ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй.

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, "Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан" ХХК -ийн Монгол улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн тухай хуулийн 23-р зүйлд заасан нэгж эрх эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно.

Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр,
Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150003, **И-мэйл:** info@moore-mongolia.mn

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Тод.	Auditlagdsan	Auditlagdsan
	2023.12.31 Mян.төг	2022.12.31 Mян.төг
Хүүгийн орлого	7	4,160,334
Ногдол ашгийн орлого	8	718,452
Бусад орлого	10	213,238
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ, цэнийй өөрчлөлт цэвэр	9	-
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз	9	489,430
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалд шилжүүлсэн бодит үнэ, цэнийй өөрчлөлт цэвэр	9	477,953
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр олз	10	596,343
Нийт орлого		6,655,750
ХОМК-ийн үйлчилгээний зардал	11	(566,497)
Кастодианы үйлчилгээний зардал	11	(83,219)
Бусад зардал	11	(74,872)
Нийт зардал		(724,588)
Татвар төлөхийн өмнөх ашиг		5,931,162
Орлогын татварын зардал	12	(226,761)
Тайлант жилийн ашиг		5,704,401
БЦОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийн үнэлгээний ашиг, цэвэр	17	(562,091)
Нийт дэлгэрэнгүй ашиг		5,142,310
Нэгж эрхийн тоо	16	50,000
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох үндсэн ашиг, төгрөг		MOORE 114
		50,000
		MOORE 82.45

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тод.	Аудитлагдсан	
		2023.12.31	2022.12.31
		Мян.төг	Мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	13	-	10,198,723
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	13	-	2,701,670
Нийт эргэлтийн бус хөрөнгө		-	12,900,393
Эргэлтийн хөрөнгө			
Хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	13	22,810,574	18,340,871
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	13	36,516,662	21,390,508
Урьдчилж төлсөн төлбөр		-	64,216
Хүүгийн авлага	14	909,385	1,188,389
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	15	121,584	1,817,900
Нийт эргэлтийн хөрөнгө		60,358,205	42,801,884
НИЙТ ХӨРӨНГӨ		60,358,205	55,702,277
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Нэгж эрх	16	50,000,000	50,000,000
Бусад нөөц	17	409,365	971,456
Хуриимтлагдсан ашиг	18	9,669,518	3,965,117
Өмчийн дүн		60,078,883	54,936,573
Богино хугацаат өр төлбөр			
Бусад богино хугацаат өр төлбөр	19	168,447	535,833
Орлогын татварын өр	20	21,499	16,633
Хойшлогдсон татварын өглөг	21	89,376	213,238
Богино хугацаат өр төлбөрийн дүн		279,322	765,704
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		60,358,205	55,702,277

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН


Тод.	Гаргасан нэгж эрх	Хурийтлагдсан ашиг	Бусад нөөц	Дүн	
				Мян.төг	Мян.төг
2021.12.31-НИЙ ҮЛДЭГДЭЛ		50,000,000	(157,351)	-	49,842,649
Тайлант жилийн ашиг	18	-	4,122,468	-	4,122,468
Бусад дэлгэрэнгүй орлого	17	-	-	971,456	971,456
2022.12.31-НИЙ ҮЛДЭГДЭЛ		50,000,000	3,965,117	971,456	54,936,573
Тайлант жилийн ашиг	18	-	5,704,401	-	5,704,401
Бусад дэлгэрэнгүй орлого	17	-	-	(562,091)	(562,091)
2023.12.31-НИЙ ҮЛДЭГДЭЛ		50,000,000	9,669,518	409,365	60,078,883

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн
салшгүй хэсэг болно.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Тод.	Auditlagdsan 2023.12.31	Auditlagdsan 2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Татварын өмнөх ашиг	5,931,162	4,488,412
Тохируулга:		
Хүүгийн орлого	7	(4,160,334)
Ногдол ашгийн орлого	8	(718,452)
Валютын ханшийн зөрүүний бодит бус гарз (олз)	10	66,395
ААБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийй ашиг	9	-
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз	9	(489,430)
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрийн хэрэгжсэн олз	9	(477,953)
Ажлын капиталын өөрчлөлт:		
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт	-	4,864,033
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бууралт	13	5,855,073
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн өсөлт	13	(12,424,484)
Урьдчилж төлсөн төлбөрийн бууралт / (өсөлт)		64,216
Бусад өглөг дансны өсөлт / (бууралт)	19	(367,386)
Төлсөн орлогын татвар	20	(132,519)
Хүлээн авсан хүү		4,439,337
Хүлээн авсан ноогдол ашиг	8	718,452
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,695,921)	664,006
Мөнгөн хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(395)
Тайлант жилийн бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,696,316)	1,813,872
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,817,900	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	121,584	

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

1. Ерөнхий мэдээлэл

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан ХХК (цаашид "сан" гэх) нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Улсын бүртгэлийн дугаар 901182609, регистрийн дугаар 6702988.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 08 сарын 18-ны өдрийн 328 дугаар тогтоолоор Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч Сан нь ТЗ 312/02 тоот тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай авсан.

Сан нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийт 50,000,000 нэгж эрх олон нийтэд санал болгосон ба тайлант оны эцэст 8,942 (2022: 8,896) нэгж эрх эзэмшигчид бүртгэлтэй байна. "Мандал Ассет менежмент" УЦК ХХК нь нийт нэгж эрхийн 5.09 (2022: 5) хувь буюу хамгийн өндөр хувийг эзэмшиж байна.

Сан нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нэгж эрхээ санал болгодог өөрийн гаргасан нэгж эрхийг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай төрлийн хөрөнгө оруулалтын сан байна.

Сан нь томоохон нээлттэй компаниудын хувьцаа болон тогтмол орлоготой үнэт цаасанд хөрөнгө оруулж, урт хугацаанд тогтвортой, өндөр өгөөжийг бий болгон Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөх үйл ажиллагаа эрхэлдэг.

Сан нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар ажилтан авч ажиллуулах үүрэггүй бөгөөд "Мандал Ассет Менежмент" УЦК ХХК нь (цаашид ХОМК) Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гол удирдлагын үүрэг хариуцлагыг хүлээдэг. Энэ гэрээний хүрээнд ХОМК-ийн гүйцэтгэх захирал Ганбат овогтой Ганзориг нь сангийн гүйцэтгэх удирдлагын эрх үүргийг хэрэгжүүлж байна.

"Голомт Банк" ХХК-ийн кастодиан үйлчилгээний хэлтэс нь сангийн кастодианы үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцоог зааварчилгааны дагуу гүйцэтгэх, хөрөнгийн үнэлгээг тооцох, тайлан мэдээллээр хангах болон нэгж эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлөх үйлчилгээ үзүүлдэг.

Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүний гудамж, Меру тауэр, 602 тоот .

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

2. Үйл ажиллагааны тасралтгүй зарчим

Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө оруулалтын сан ХХК нь 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 5,704,401 (2022: 4,122,468) мян.төгрөгийн цэвэр ашигтай, 60,078,883 (2022: 54,936,573) мян.төгрөгийн цэвэр хөрөнгөтэй ажилласан байна.

Сангийн энэхүү тайланг баталснаас хойш тасралтгүй зарчмын дагуу үйл ажиллагаа явуулах нь ХОМК буюу гүйцэтгэх захирлын ирээдүйд ашгийг нэмэгдүүлж ажиллах чадвар, нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн өсөлт, хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэл зэргээс хамаарах ба энэхүү тайлангийн өдрөөр Сангийн үйл ажиллагааны тасралтгүй зарчимд эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал үүсээгүй байна.

2023 онд Монгол улсын эдийн засаг макро орчны хувьд сэргэлттэй байсан бөгөөд уул уурхайн болон санхүүгийн салбарын өсөлтөөс шалтгаалан жилийн эцэст дотоодын нийт бүтээгдэхүүн 5.8 (2022: 5) хувийн өсөлттэй байсан ба 2024 онд 6.2 хувьд хүрэхээр хүлээгдэж байна.¹

Хэдийгээр дотоодын эдийн засаг өсөх хандлагатай байгаа боловч олон улсад геополитикийн асуудлууд эрчимтэй өрнөж байгаа энэ үед эдгээр үйл явдлын дотоодын эдийн засагт үзүүлэх нелөө, цаашлаад Сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тулгарч болох аливаа эрсдэлийг урьдчилан үнэлж, хариу арга хэмжээнд бэлтгэлтэй байх шаардлагатай.

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

3.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо ("НББОУСХ")-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлagnalын Олон Улсын Стандарт ("СТОУС") болон СТОУС-ын Тайлбарын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны батлагдсан заавар журмуудыг даган мөрдсөн болно. Санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилж бэлтгэгдсэн бөгөөд тодорхой санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгүүд нь холбогдох стандартын шаардлагуудын дагуу илэрхийлэгдсэн. Сангийн тайлagnalын болон үйл ажиллагааны валют нь Монгол Улсын төгрөг юм. Энэхүү санхүүгийн тайлан нь төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр (мян.төг) нарийвчлагдсан болно.

¹ Дэлхийн банк, 2023 оны 11 сарын 28-ны өдрийн Mongolian economic update

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.1 Тайлан бэлтгэх үндэслэл (Үргэлжлэл)

Олон Улсын Тогтвортой Байдлын Стандартын зөвлөлөөс 2023 оны 06 сард цаг уурын өөрчлөлтэй холбоотой Тогтвортой байдлын стандартуудыг баталсан. Эдгээр санхүүгийн тайлан нь тус Тогтвортой байдлын стандартаар шаардсан тодруулгыг агуулаагүй бөгөөд дотоодын дүрэм журмаар тус стандартыг дагаж мөрдөхийг шаардсан тохиолдолд Тогтвортой байдлын тодруулгыг тусдаа бэлтгэнэ.

3.2. Шинэ болон нэмэлт өөрчлөлт бүхий стандартууд болон тайлбарууд

Дараах стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс болон дараагийн тайлант үеүдэд хүчин төгөлдөр мөрдөгднө:

- СТОУС 17 Даатгалын гэрээ
- НББОУС 1 болон СТОУС практикийн мэдэгдэл 2 Нэмэлт өөрчлөлт
- НББОУС 8 НББ-н тооцоолол нэмэлт өөрчлөлт
- НББОУС 12 Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүсч буй хөрөнгө, өр төлбөрийн хойшлогдсон татварын асуудал

Дээрх стандартуудын өөрчлөлтүүдээс Санд хамааралтай хэсгүүдийг дэлгэрүүлбэл дараах байдалтай байна:

НББОУС 1 болон СТОУС практикийн мэдэгдэл 2 Нэмэлт өөрчлөлт- Бүртгэлийн бодлогын тодруулга-Энэхүү нэмэлт өөрчлөлт нь дараах зүйлсийг өөрчилсөн:

- СТОУС 7, Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд санхүүгийн хэрэгслийн хэмжилтийн суурь нь материаллаг байна,
- НББОУС 1, Аж ахуйн нэгжүүдийг гол бүртгэлийн бодлогоос илүүтэйгээр материаллаг бүртгэлийн бодлогыг тодруулахыг шаардаж байгаа,
- НББОУС 34, Материаллаг бүртгэлийн бодлогыг иж бүрэн сет санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болгож тодорхойлох,
- СТОУС практикийн мэдэгдэл 2, материаллаг бүртгэлийн бодлогын тодруулга болон түүнийг хэрхэн тодорхойлох талаар удирдамжаар хангасан.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг ирээдүйд гүйцээн мөрдөх горимын дагуу ашиглана.

НББОУС 8 НББ-ийн тооцоолол нэмэлт өөрчлөлт- Аж ахуйн нэгж байгууллагуудыг НББ-ийн тооцоолол болон НББ-ийн бодлогын өөрчлөлтийг хэрхэн ялгахыг тодорхой болгохыг шаардсан. Мөн санхүүгийн тайланд хэмжилтийн тодорхойгүй байдлаас үүдэлтэй мөнгөн дунг тодорхой тодруулах талаар нэмж өөрчилсөн.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг ирээдүйд гүйцээн мөрдөх горимын дагуу ашиглана.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

3.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбарууд

Дараах батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд Сангийн санхүүгийн тайланд нөлөөлж болзошгүй байгаа бөгөөд эдгээр стандарт болон тайлбаруудыг 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс цааш хүчин төгөлдөр хугацаанаас мөрдөх болно:

- НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт- Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
- НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт- Эргэлтийн бус өр төлбөрийн гэрээний нөхцөлүүд (ковинантс)
- НББОУС 7 ба СТОУС 7- Нийлүүлэгчийн санхүүжүүлэх нөхцөлтэй гэрээ
- СТОУС 16 Нэмэлт өөрчлөлт- Борлуулаад буцаан түрээслэх үеийн түрээсийн өр төлбөр
- СТОУС 10 ба НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт- Хөрөнгө оруулагч ба хараат компани, хамтарсан үйлдвэр хоорондын хөрөнгийн борлуулалт ба хандивын ажил гүйлгээ

3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй

3.4.1 Сегментийн мэдээлэл

Сангийн бүх санхүүгийн шийдвэрүүд нь цогц байдлаар гардаг бөгөөд Санд үйл ажиллагааны ашиг алдагдал, хөрөнгө өр төлбөрийг тусад нь хэмждэг нэгж байхгүй тул санхүүгийн тайлан нь нэг сегментийн дагуу бэлтгэгдсэн.

3.4.2 Орлого

Хүүгийн орлогыг бодит үнэ цэн нь ашиг алдаглаар бүртгэдэг өрийн хэрэглүүр бүрийн хувьд аккруэл сууриар нэрлэсэн хүүгээр тооцож бүртгэдэг. Бусад тохиолдолд аккруэл сууриар үр ашигт хүүгийн аргаар тооцож бүртгэдэг.

Ногдол ашгийн орлогыг хүлээн авах нь тодорхой болсон, тогтоол шийдвэрээр баталгаажсан үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

3.4.3 Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд нь анх ажил гүйлгээний үнэтэй ойролцоо байх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ. Ашиг алдагдал болох бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгүүдийн хувьд ажил гүйлгээний үнэ нь дансны үнэ рүү тохируулагдана.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бodoх бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

**3.4 Ашигласан нягтлан бodoх бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй
(Үргэлжлэл)**

3.4.3 Санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Ашиг алдагдал болох бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө

Үндсэн төлбөр, хүү төлөлтийг цуглуулах зорилгогүй өрийн болон өмчийн хэрэгслийг бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэний өөрчлөлтийг санхүүгийн орлого зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр хэмжигдэх өмчийн хэрэглүүр (БДОБҮЦ)

Компани урт хугацаанд эзэмших стратегийн хөрөнгө оруулалт болох өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг БДОБҮЦ-р хэмжих сонголт хийсэн. Хэрэв хөрөнгө оруулалтыг борлуулсан тохиолдолд өмчийн хэсэгт БДО-р хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэний өсөлт бууралтыг хуримтлагдсан ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. Дээрх үнэт цааснаас ногдол ашиг авах эрх бий болсон үед орлогоор хүлээн зөвшөөрнө. Ул хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгүүдийг дараах нөхцөлүүд биелсэн үед үл хүлээн зөвшөөрнө:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх/гадагшлах мөнгөн урсгалыг хүлээн авах гэрээний эрх дуусгавар болсон; эсвэл
- Орж ирэх мөнгөн урсгалыг хүлээн авах гэрээний эрх шилжсэн болон уг хөрөнгийн эрсдэл, өгөөжийн ихэнх нь бусдад шилжсэн эсвэл санхүүгийн хөрөнгийн хяналт шилжсэн.

3.4.4 Санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрийг анх ажил гүйлгээний үнэтэй ойролцоо байх бодит үнэ цэнээр хэмжинэ. Санхүүгийн өр төлбөрийг дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих бөгөөд хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргаар ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Ул хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийн гэрээний үүрэг барагдсан, цуцлагдсан, хугацаа нь дууссан эсвэл бусад стандартын шаардлагыг хангасан үед санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө. Ул хүлээн зөвшөөрөлтийн үед дансны үнэ болон төлсөн дүн хоёрын зөрүүнээс үүссэн олз, гарзыг ашиг алдагдаар хүлээн зөвшөөрнө. Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн (Зээл болон зээллэг) гэрээний ихэнх нөхцөлүүд өөрчлөгдсөн бол хуучин өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч шинэ санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

**3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй
(Үргэлжлэл)**

3.4.4 Санхүүгийн өр төлбөр (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэгслүүдийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө өр төлбөрүүдийг зөвхөн тэдгээрийг цэвэр дүнгээр хаах эсвэл нэгэн зэрэг барагдуулах хууль ёсны эрхтэй тохиолдолд Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө өр төлбөрүүдийг хааж цэвэр дүнгээр харуулна. Тайлагналын өдрөөр Компанид цэвэршүүлж хаасан санхүүгийн хөрөнгө, өр төлбөр байгаагүй.

3.4.5 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгүүд

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгүүд нь гар дээрх бэлэн мөнгө, банкны харилцах дахь мөнгө болон 3 сар буюу түүнээс бага хугацаатайгаар хийсэн хөрөнгө оруулалтууд, мөнгөнд хөрвөхөд бэлэн байгаа санхүүгийн хэрэгслүүдээс бүрдэнэ.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь тайлагналын өдрөөрх гадаад валютын ханшаар илэрхийлэгдэн бодит үнэ цэнээр хэмжигддэг.

3.4.6 Нэгж эрх ба нэгж эрхэд ногдох ашиг, ногдол ашиг

Нэгж эрх

Сангийн хувьд гаргасан нэгж эрхийг өмчөөр ангилсан. Хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэн нь нэрлэсэн үнээс давсан үед нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэдэг.

Ногдол ашиг

Ногдол ашиг гэдэг нь нэгж эрх эзэмшигчдийн санд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж юм. Сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар нэгж эрхэд ногдол ашиг олгох шийдвэр баталгаажсан тайлант үед өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Нэгж эрхэд ногдох ашиг

Сангийн нэгж эрхэд ногдох ашиг (алдагдал) гэдэг нь жилийн турш эргэлтэд байсан нэгж эрхийн жинлэсэн дундаж тоонд ногдох цэвэр ашиг алдагдал юм. Сан нь нэгж эрхэд ногдох үндсэн ашгийг тооцож толилуулдаг.

3.4.7 Гадаад валютаарх ажил гүйлгээ

Сангийн үндсэн валют, төгрөгөөс бусад валютын гүйлгээ нь гадаад валютаарх ажил гүйлгээнд тооцогдоно. Төгрөгөөс бусад валютаар хийгдсэн ажил гүйлгээ нь тухайн өдрийн албан ханшаар хөрвүүлэгдэж бүртгэлд тусгагдана.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

**3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй
(Үргэлжлэл)**

3.4.7 Гадаад валютаарх ажил гүйлгээ (Үргэлжлэл)

Тайлагналын өдрөөрх гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө болон өр төлбөрүүд нь тайлагналын өдрийн албан ханшаар дахин илэрхийлэгдэнэ. Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн, гадаад валютаарх мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүд нь бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн албан ханшаар илэрхийлэгдэнэ.

Ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

3.4.8 Татварын зардал

Татварын зардал нь одоогийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэнэ. Одоогийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох тайлангийн өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцогдоно.

Тайлант жилийн татвар ногдох орлого гэдэг нь хөрөнгө оруулалтын сангийн хувьд үйл ажиллагааны бус орлогод татварын хуулийн дагуу зөвшөөрөгдхөн болон үл зөвшөөрөгдхөн зүйлсээр тохируулсан дүн юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэ ба татварын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн, ирээдүйд төлөгдөх эсвэл буцаан авахаар хүлээгдэж буй өр төлбөрийн аргыг ашиглан бүртгэсэн татвар юм.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1.15²-д зааснаар Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого нь татвараас чөлөөлөгдсөн боловч сангийн удирдлага нь тайлант үеийн эцэст татварыг суутган тооцож, төлөх үүрэгтэй харилцагчийн байр суурийг үнэлж, татварын байгууллагаас татвар ногдуулах өндөр магадлалтай ажил гүйлгээг тодорхойлж, татварыг ногдуулж тайлагнасан. Энэхүү шийдвэрийг гаргахдаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд даган мөрдөх үүрэгтэй дүрэм журмыг мөн харгалзан үздэг.

3.4.9 Холбоотой талууд

Сан нь өөр аж ахуйн нэгжийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх, эсвэл хяналт тавих эрхтэй бол холбоотой талууд болно. Хэрвээ Сангийн санхүүгийн болон удирдлагын шийдвэр гаргалтад хувь хүн эсвэл өөр аж ахуйн нэгж шууд ба шууд бусаар нөлөө үзүүлдэг, эсвэл хяналт тавьдаг бол мөн холбоотой талууд гэж тодорхойлдог.

² 21.1.15- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого нь татвараас чөлөөлөгднө.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд (Үргэлжлэл)

**3.4 Ашигласан нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын хураангуй
(Үргэлжлэл)**

3.4.9 Холбоотой талууд (Үргэлжлэл)

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад компаниуд байж болно.

Санг хянадаг, сангийн гол удирдлага эсвэл мэдэгдэхүйц нөлөөтэй нэгж эрх эзэмшигчид, тэдгээрийн гэр бүлийн ойр дотнын гишүүд; болон нөлөө бүхий нэгж эрх эзэмшигчдийн хяналтад байдаг эсвэл тэдгээрийн мэдэгдэхүйц нөлөөтэй аж ахуйн нэгжүүд нь мөн холбоотой талууд болно.

Мөн нэг группийн бүрэлдэхүүнд багтдаг компаниуд, хараат, хамтарсан хөренгө оруулалттай компаниудын холбоотой тал болно. Холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ гарсан эсэхээс үл хамааран тэдгээрийн хоорондын харилцааг тодруулах ёстой.

Холбоотой талуудын ажил гүйлгээний тодруулгад дараах зүйлсийг тодруулна.

- Хөрөнгө оруулалт;
- Борлуулалт/ худалдан авалт;
- Худалдааны болон бусад авлага/өглөг;
- Бусад

Сан нь санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Сан нь хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөр үнэт цаасны арилжаа, хөрөнгө оруулалт хийдэг тул үйл ажиллагаа болон санхүүгийн хэрэгслүүдээс үүдэлтэй дараах эрсдэлүүдэд өртөж болно:

1. Зах зээлийн эрсдэл
2. Хөрвөх чадварын эрсдэл
3. Зээлийн эрсдэл
4. Капиталын эрсдэлийн удирдлага

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр санхүүгийн хэрэгсэл болон өдөр тутмын үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлүүдийг удирдан, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, ёсгөх үндсэн зорилготой.

Сангийн эрсдэлд өртөж болзошгүй санхүүгийн хэрэгслүүд нь банкин дахь харилцах, хадгаламж, хөрөнгө оруулалтууд, бусад авлага болон өглөгүүд юм. Хөрөнгө оруулалтын менежментийн компани эрсдэлийн удирдлагыг хариуцдаг боловч эрсдэлийг тодорхойлох, хянах үүргийг гүйцэтгэх захирал хариуцдаг.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.1 Зах зээлийн эрсдэл

Сан нь санхүүгийн хэрэгслүүдийн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл бодит үнэ цэн зах зээлийн үзүүлэлтээс болж хэлбэлзсэнээс шалтгаалан зах зээлийн эрсдэлд өртөх магадлалтай байдаг бөгөөд Сангийн өртөж болох зах зээлийн эрсдэлүүд нь гадаад валютын ханшийн эрсдэл, хүүгийн түвшний эрсдэл юм.

Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын эрсдэл нь Сангийн худалдан авалт, борлуулалт эсвэл хөрөнгө оруулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа тайлагналын валютаас өөр валютаар хийгддэгээс шалтгаалан үүсэж болох эрсдэл юм.

Ханшийн хэлбэлзэл нь зах зээлд тодорхой бус байдлыг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулагчдын шийдвэрт шууд болон шууд бусаар нөлөө үзүүлдэг. Иймд Сангийн удирдлага нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасны дагуу ханшийн таамаглал эрсдэлийг тооцон үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг авч үзэн ажилладаг.

Санхүүгийн тайланд толилуулсан гадаад валютаарх хөрөнгө, өр төлбөрийн дүнгүүдийг харуулбал:

	2023.12.31	2022.12.31
	USD	USD
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	313	522,016
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	213,000	2,959,000
Хүүгийн авлага	4,581	78,433
Нийт валютаарх хөрөнгө	217,894	3,559,449

Сангийн ашигладаг гол валютуудын тайлангийн өдрөөрх төгрөгийн тухайн валюттай харьцах хаалтын ханш болон тайлант оны дундаж ханш дараах байдалтай байна:

	2023	2022
	USD	USD
Хаалтын ханш	3,410.7	3,444.6
Дундаж ханш	3,465.6	3,141.4

Сангийн хувьд төгрөг болон тухайн гадаад валютуудын харьцах хаалтын ханш 12 сарын 31-нээр 10 хувиар чангараахад Сангийн цэвэр хөрөнгө, ашиг алдагдалд дараах нөлөөтэй байна.

USD	Ашиг (алдагдал) Мян.төг	Өмч Мян.төг
2023 он	74,317	66,885
2022 он	1,226,223	1,103,479

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.1 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Төгрөгийн эдгээр валютуудтай харьцах хаалтын ханш 10 хувь сулрахад энэ нь ашиг алдагдал, өмчид дээрх дүнгүүдээр эсрэгээр нелөөлнэ.

Энэхүү мэдрэмтгий байдлын шинжилгээ нь хүүгийн түвшин зэрэг валютын ханшаас бусад хувьсагчид нь өөрчлөгдөхгүй гэж үзэн хийгдсэн болно.

Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшин өөрчлөгдсөний улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн эсвэл ирээдүйн мөнгөн урсгалд нелөөлөх эрсдэл юм.

Сангийн удирдлага хүүгийн түвшний эрсдэлийг удирдахын тулд хүүгийн түвшний өөрчлөлт таамаглалыг улирал бүр шинэчилж, Сангийн мөнгөн хөрөнгийг эрсдэл даах чадвартай банканд байршуулах, эрсдэлийг харгалzan өндөр өгөөжтэй санхүүгийн хэрэгслийг сонгон хөрөнгө оруулалт хийх эсвэл арилждаг.

Тайлагналын өдрөөр Сангийн тогтмол болон хувьсах хүүтэй санхүүгийн хэрэгслүүд нь дараах байдалтай байсан.

	2023.12.31 /Мян.төг/	2022.12.31 /Мян.төг/
Тогтмол хүүтэй хэрэгслүүд:		
Банкин дахь хадгаламж	22,084,097	18,340,871
МХБ-д арилжаалагддаг нээлттэй бонд	18,569,490	11,484,569
Монгол Улсын Засгийн Газрын бонд	726,477	10,198,723
	41,380,064	40,024,163

Бодлогын хүү 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 13 (2022: 6.5-13) % байсан ба Сангийн эзэмшдэг хүүтэй хэрэгслүүдийн хувьд арилжааны банкинд байршуулсан хугацаатай хадгаламж жилийн 6-17.5 хувийн хүүтэй, бусад компанийн өрийн бичгүүд 17.5-19.6 хувийн хүүтэй, Засгийн газрын бондын хувьд жилийн 8.45 хувийн хүүтэй байна.

Хүүгийн түвшин 10 хувь өсөхөд ашигт үзүүлэх нелөө 416,033 (2022: 408,689) мянган төгрөг, өмчид үзүүлэх нелөө 374,430 (2022: 367,820) мянган төгрөг байна. Энэхүү мэдрэмжийн шинжилгээ нь хүүгийн түвшнээс бусад үзүүлэлтүүд тогтмол байна гэсэн төсөөлөл дээр хийгдсэн. Хүүгийн түвшин 10 хувь буурахад эдгээр дүнгээр ашиг алдагдал ба өмчийг бууруулах нелөөтэй байна.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. Санхүүгийн эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

4.2 Хөрвөх чадварын эрсдэл

Сан нь төрөл бүрийн үүрэг хариуцлагыг гэрээний дагуу хүлээдэг бөгөөд гэрээний үүргээ биелүүлэхэд шаардлагатай богино хугацаат санхүүгийн хэрэгцээг биелүүлэх чадваргүй болж болзошгүй эрсдэлийг хөрвөх чадварын эрсдэл гэнэ.

Зах зээлийн хурдан хувьсамтгай нөхцөл байдлаас шалтгаалж хөрөнгө оруулалтыг буцаан худалдан борлуулж чадахгүй байх эсвэл алдагдалтай үнээр худалдах, эсвэл тохиромжгүй цагт худалдан авах, борлуулах, эсвэл үнэт цаас гаргагч нь урьдчилан тооцоолох боломжгүй байдлаар төлбөрийн чадваргүй болох төлбөр төлөлт хойшлогдох эрсдэл үүсдэг.

Үүнээс шалтгаалан бусад хөрөнгө оруулалт хийх боломжоо давхар алдах эрсдэлтэй.

Дараах хүснэгтэд Сангийн санхүүгийн болон татварын өр төлбөрүүдийн гэрээний дагуух хүү болон үндсэн төлбөр төлөлтийн хорогдуулаагүй мөнгөн урсгалыг харуулав.

2023 оны 12 сарын 31-нээр	Дансны үнэ	<3 сар	3-6 сар	6 сар-1 жил
		Мян.төг	Мян.төг	Мян.төг
Бусад өглөг	168,447	168,447	-	-
Татварын өглөг	21,499	21,499	-	-
НИЙТ	189,946	189,946	-	-

2022 оны 12 сарын 31-нээр	Дансны үнэ	<3 сар	3-6 сар	6 сар-1 жил
		Мян.төг	Мян.төг	Мян.төг
Бусад өглөг	535,833	535,833	-	-
Татварын өглөг	16,633	16,633	-	-
НИЙТ	552,466	552,466	-	-

4.3 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь харилцагч байгууллага санхүүгийн хөрөнгийн гэрээний үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл бөгөөд үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээ, түрээсийн авлага, бусдад олгосон зээл зэрэг бүх санхүүгийн хөрөнгийн хувьд Компанид алдагдал учирч болзошгүй. Компанид учирч болох зээлийн алдагдлын дээд хэмжээ нь санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ байна.

Зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахын тулд санхүүгийн хөрөнгө байршуулах, зээл олгох байгууллагыг ХОМК эрсдэлийн удирдлагын бодлого горимуудын дагуу сонгож хяналт хэрэгжүүлдэг.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

4.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэл нь төрөл бүрийн өрийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтууд, бусад авлагууд, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгүүд болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж зэргээс үүснэ.

Санхүүгийн хөрөнгүүдийн хувьд зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн болон үнэ цэн нь буурсан гэсэн бодит нотолгоо байгаа зэргээс хамааран нийт хугацааны зээлийн алдагдлын арга, 12 сарын хугацааны зээлийн алдагдлын аргыг ашиглах бөгөөд санхүүгийн хөрөнгүүдийн төрөл бүрээр дараах байдалтай байна.

Сангийн удирдлага нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хэрэгслүүдэд (Монгол улсын засгийн газрын бонд, нээлттэй зах зээлд арилжаалагддаг өрийн болон өмчийн хэрэгслүүд) хөрөнгө оруулахын зэрэгцээ үнэт цаас бүрийн хөрвөх чадварын үнэлгээг тодорхойлж, хууль болон хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэн зээлийн эрсдэлийг боломжит бага хэмжээнд байлгахыг зорин ажилладаг.

Банканд байршуулсан харилцах, хадгаламж

Компани аль болох өндөр кредит үнэлгээтэй, найдвартай санхүүгийн байгууллагад мөнгөн хөрөнгийг байршуулахыг зорьдог.

Тайлант оны хувьд Хаан, Богд, М банкин дахь мөнгө нийт мөнгөний 97.23 хувийг эзлэх бөгөөд эдгээр банкуудын зээлжих зэрэглэлийн үнэлгээний мэдээлэл дараах байдалтай байна:

	Үнэлгээний байгууллага	Зээлжих зэрэглэл
Хаан банк	Moody's	Тогтвортой ⁴
Богд банк	Moody's	B3 (тогтвортой) ⁵

Сан нь банканд байршуулсан харилцах, хадгаламжид 12 сарын хугацааны зээлийн алдагдлын арга ашиглан үнэлгээ хийдэг бөгөөд тайлант онуудын эцэст зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц өссөн, төлбөрийн чадваргүй болсон харилцагч байхгүй тул зээлийн алдагдлын сан байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

⁴ 2022 оны 10 сарын 06-ны өдрийн үнэлгээ

⁵ 2021 оны 03 сарын 22-ны өдрийн үнэлгээ

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

4.3 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

ААБҮЦ болон БДОБҮЦ-р хэмжигдэх өрийн хэрэгслүүд

ААБҮЦ⁶ болон БДОБҮЦ⁷-р хэмжигдэх өрийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэлийн үнэлгээг тооцоходоо үнэт цаас гаргагчийн зээлжих чадварын үнэлгээ (боловтой бол), хугацаандаа төлбөрөө төлөх байдал, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар, идэвхтэй арилжаалагдах байдал зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үздэг. Сан нь зохицуулагч байгууллагаас шаардсаны дагуу ихэвчлэн нээлттэй зах зээлд арилжаалагдаж буй өрийн хэрэгсэл болон Засгийн газрын бондод хөрөнгө оруулалт хийдэг тул зээлийн эрсдэл харьцангуй бага байна.

Тайлант хугацааны эцэст байгаа тус ангиллын санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хугацаа хэтрэлттэй, эсвэл төлбөр төлөлтөө хугацаа хэтрүүлсэн тохиолдол байгаагүй ба 12 сарын хугацааны зээлийн алдагдлын арга ашиглан тооцоход материаллаг дүнтэй зээлийн алдагдал байгаагүй тул удирдлага хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

4.4 Капиталын эрсдэлийн удирдлага

Сангийн капитал нь нэгж эрхээс бүрдэнэ.

Сан нь хөрөнгө оруулалт хийх замаар нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол өсгөх зорилготой ба Сангийн удирдлага нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой бодлогуудыг хөгжүүлж бий болгодог. Тайлант хугацаанд Сангийн капиталыг удирдах бодлогод өөрчлөлт ороогүй.

Сангийн цэвэр активын үнэлгээг цэвэр активыг нэгж эрхийн тоонд харьцуулсан харьцаагаар хэмждэг. Цэвэр активыг тооцоходоо нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хасаж тооцно.

Сангийн цэвэр хөрөнгийг харуулбал:

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Нийт хөрөнгө	60,358,205	55,702,277
Нийт өр төлбөр	279,322	765,704
Цэвэр актив	60,078,883	54,936,573
Нэгж эрхийн тоо	50,000	50,000
Цэвэр активын үнэлгээ, төгрөг	1,201.58	1,098.73

⁶ Ашиг алдагдал болох бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн хөрөнгө

⁷ Бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн хөрөнгө

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

4. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

4.4 Капиталын эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

Сан нь өдөр бүр нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгийг тооцоолох бөгөөд цэвэр активын хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид үйл ажиллагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь эсвэл түүнээс дээш хэмжээгээр буурсан тохиолдолд сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж санг татан буулгах, хэрэв хөрөнгө оруулагчдын хурлаас татан буулгахгүй байхаар шийдвэрлэх нөхцөлд хөрөнгө оруулагчдад учирч болох эрсдэлийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид нь хүлээхэд татгалзах зүйлгүй тухай хэлэлцэж шийдвэр гаргана.

5. Бодит үнэ цэний хэмжилт

Сан нь санхүүгийн тайланд зарим санхүүгийн хөрөнгө өр төлбөрүүдийг бодит үнэ цэнээр тусгадаг.

Бодит үнэ цэн гэдэг нь хэмжилтийн өдрөөр зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгө өр төлбөрүүдийн дэс дугаартай ажил гүйлгээгээр хүлээн авах эсвэл шилжүүлэх төлбөрийн дүнгээр тодорхойлогддог. Хэрэв хөрөнгө өр төлбөр нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаг бол тухайн зах зээлийн үнийг ашиглана, идэвхтэй зах зээл байдаггүй бол үнэлгээний техникуудийг ашиглан хөрөнгө өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмждэг. Ингэхдээ үл ажиглагдахуйц өгөгдлийг хамгийн бага түвшинд, шууд ажиглагдах өгөгдлийг их хэмжээгээр ашиглахыг зорьдог.

Бодит үнэ цэний хэмжилтэд хэрэглэгдэх өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг.

Бодит үнэ цэний шатлал:

Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх тогтоогдсон хөрөнгө, өр төлбөрийн үнэ

Түвшин 2: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд ба шууд бус өгөгдөл ашигласан

Түвшин 3: Үл ажиглагдахуйц өгөгдөл ашигласан (зах зээлийн бус мэдээлэл)

Санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэн нь тайлант өдрөөр дараах байдалтай байна:

2023.12.31-НИЙ ӨДӨР	Түвшин 1 Мян.төг	Түвшин 2 Мян.төг	Нийт Мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Хорогдуулсан өргтөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	-	22,810,574	22,810,574
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	36,516,662	-	36,516,662
Хүүгийн авлага	-	909,385	909,385
Мөнгөн хөрөнгө	-	121,584	121,584
Нийт санхүүгийн хөрөнгүүд	36,516,662	23,841,543	60,358,205
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өглөг	-	168,447	168,447
Нийт санхүүгийн өр төлбөрүүд	-	168,447	168,447

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

5. Бодит үнэ цэний хэмжилт (Үргэлжлэл)

2022.12.31-НИЙ ӨДЕР	Түвшин 1 Мян.төг	Түвшин 2 Мян.төг	Нийт Мян.төг
Санхүүгийн хөрөнгө			
Хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	-	28,539,594	28,539,594
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө	24,092,178	-	24,092,178
Хүүгийн авлага	-	1,188,389	1,188,389
Мөнгөн хөрөнгө	-	1,817,900	1,817,900
Нийт санхүүгийн хөрөнгүүд	24,092,178	31,545,883	55,638,061
Санхүүгийн өр төлбөр			
Бусад өглөг	-	535,833	535,833
Нийт санхүүгийн өр төлбөрүүд	-	535,833	535,833

6. Ашигласан гол тооцоолол ба мэргэжлийн шийдлүүд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага тайлагнасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, болзошгүй хөрөнгө, өр төлбөрүүдэд болон тэдгээрийн тодруулгад нөлөөлөх тооцоолол болон төсөөллүүдийг хийх шаардлагатай болдог. Ирээдүйд эдгээрийн бодит үр дүн тооцоолсон дүнгээс ялгаатай байж болно.

Мэргэжлийн шийдэл

Мэдэгдэхүйц мэргэжлийн шийдэл болон тооцоолол ашигласан хөрөнгө, өр төлбөрийн зүйлс дараах байдалтай байгаа бөгөөд холбогдох тодруулгуудад дэлгэрэнгүй тодруулсан.

1. Санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд:

- Идэвхтэй зах зээлд арилжаалагдаг санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг үнэлгээний өдрийн биржийн арилжаа хаах үеийн зах зээлийн үнэд үндэслэн тооцоолдог.
- Идэвхтэй зах зээлд арилжаалагдаггүй санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг тооцоходоо ижил төстэй хөрөнгийн идэвхтэй бус зах зээлийн жишиг үнэ, нөхцөлт өөрчлөлт, зээлийн тархалт, гэрээний хүүгийн түвшин болон жишиг ашиглаж болохуйц хүүгийн түвшин, үнэлгээний арга зүй болон ул үндэслэлтэй байж болох зүйлсийг харгалzan үздэг.

2. Хяналт болон мэдэгдэхүйц нөлөөллийг тогтооход ашигласан мэргэжлийн шийдэл – Сангийн үндсэн зорилго нь хөрөнгө оруулалтаас хүртэх өгөөжийг өндөр байлгах бөгөөд дийлэнх тохиолдолд өмчийн хэрэглүүрийг худалдан борлуулах зорилготой учир хяналт хэрэгжүүлэхгүй гэсэн төсөөлөл, таамаглал ашигладаг. Ажил гүйлгээний хувьд шийдвэр гаргалтын оролцоо, ажил гүйлгээний үзүүлэх үр нөлөө, холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил шинж чанартай ажил гүйлгээнээс ялгаатай болон төсөөтэй талуудыг харгалzan үздэг.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

6. Ашигласан гол тооцоолол ба мэргэжлийн шийдлүүд (Үргэлжлэл)

Тооцоолол

Дараах хөрөнгө өр төлбөрийн дансны үнэд ашигласан тооцоолол төсөөллөөс шалтгаалан материаллаг хэмжээний залруулга дараагийн тайлант үед хийгдэж болзошгүй бөгөөд эдгээрийг ирээдүйд бүртгэх аргын дагуу бүртгэнэ.

Хэмжилт болон тодруулгадаа бодит үнэ цэний тооцоолол шаарддаг санхүүгийн тайлангийн хэсгүүд нь санхүүгийн хөрөнгө өр төлбөрүүд бөгөөд эдгээр хөрөнгө өр төлбөрийн бодит үнэ цэний шатлалын мэдээллийг Тодруулга 5-д харуулсан.

7. ХҮҮГИЙН ОРЛОГО

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авсан хүүгийн орлого		
Нээлттэй бондын хүүгийн орлого (Тод.13)	1,873,289	1,142,187
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого		
Хугацаат хадгаламжийн хүүгийн орлого (Тод.13)	1,370,087	2,662,056
Засгийн газрын бондын хүүгийн орлого (Тод.13)	916,958	282,646
	4,160,334	4,086,889

8. НОГДОЛ АШГИЙН ОРЛОГО

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
БДОБҮЦ -ээр хэмжсэн өмчийн хэрэглүүрээс хүлээн авсан ногдол ашиг (Тод.13)	718,452	37,579
	718,452	37,579

9. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨӨС ҮҮССЭН ОЛЗ, ГАРЗ

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ, цэний цэвэр өөрчлөлт	-	246,031
БДОБҮЦ-р хэмжсэн өмч, өрийн хэрэглүүрийн арилжааны олз	154,955	-
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз	489,430	-
БДОБҮЦ-р хэмжсэн санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалд шилжүүлсэн бодит үнэ, цэний цэвэр өөрчлөлт	322,998	-
	967,383	246,031

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

10. БУСАД ОЛЗ (ГАРЗ)

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Валютын ханшийн зөрүүний бодит олз	662,738	164,604
Валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз)	(66,395)	1,149,866
Бусад орлого	213,238	-
	809,581	1,314,470

Сангийн үйл ажиллагааны орлого нь 2023.01.01-ний өдрөөс эхлэн татвараас чөлөөлөгдсөн тул өмнөх тайлант жилд үүсгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийг бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн.

11. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
ХОМК-ийн үйлчилгээний зардал	566,497	971,982
Кастодианы үйлчилгээний зардал	83,219	94,220
Мэргэжлийн үйлчилгээний зардал	66,733	59,075
Шимтгэлийн болон бусад зардал	8,139	71,280
	724,588	1,196,557

Сан нь Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу ХОМК-д тухайн жилд төлөх үйлчилгээний төлбөр нь сангийн цэвэр активын үнэлгээний 1 хувьтай тэнцүү байх ба уг үйлчилгээний төлбөрийг сар бүр тэнцүү хувааж төлнө. ХОМК-д төлөх урамшуулал нь сангийн жилийн нийт ашгийн 10 хувьтай тэнцүү байх ба жилд нэг удаа төлдөг. “Мандал Ассет Менежмент” УЦК ХХК нь сангийн өгөөжийг өндөр байлгах зорилгоор 2023 оны гүйцэтгэлийн урамшууллыг авахгүй байхаар ТУЗ-ийн тогтоолоор шийдвэрлэсэн байна.

Сан нь Голомт банкнаас кастодианы үйлчилгээ авдаг. Кастодиан банк нь хөрөнгө хадгалсны хураамжийг үнэт цаас болон сангийн бусад хөрөнгийн дүнгээс 10 хувиар тооцон нэхэмжилдэг.

12. ОРЛОГЫН ТАТВАР

Тайлант жилийн татварын зардлыг Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй тайлангийн ашиг алдагдалд хэрхэн зохицуулсныг доор харуулав:

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

12. ОРЛОГЫН ТАТВАР (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
Тайлант жилийн татвар:		
Татварын өмнөх ашигт ногдох татвар	-	448,841
Тусгайлан хувь хэмжээтэй татварын нөлөөлөл	116,062	(57,109)
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	-	(58,130)
Нийтлэг хувь хэмжээтэй татварын нөлөөлөл	21,323	-
	137,385	333,602
Хойшлогдсон татвар		
Өмнө нь хүлээн зөвшөөрсөн түр зөрүү	-	(53,074)
Тайлант онд хүлээн зөвшөөрсөн түр зөрүү	89,376	85,416
	89,376	32,342
Нийт тайлант жилийн татвар	226,761	365,944

Сан нь өмнөх тайлант жилүүдэд хүчин төгөлдөр мөрдэж байсан хуулийн дагуу 6 тэрбум төгрөг хүртэлх ашгаас 10%-ийн орлогын албан татвар, түүнээс дээш ашигт 25%-ийн орлогын албан татвар төлдөг байсан.

Тайлант оны 01 сарын 01-нээс эхлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1.15¹⁰-д зааснаар Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого нь татвараас чөлөөлөгдсөн.

Сан нь үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй орлогод нийтлэг хувь хэмжээгээр 21,323 мянган төгрөгийн татвар ногдуулж тайлагнасан (Тод.10).

Арилжааны банкнууд харилцах дансны үлдэгдэл болон хадгаламжийн хүүгийн орлогоос тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулж, суутган төлсөн 116,026 (2022: 57,109) мянган төгрөгийн татварыг зардлаар бүртгэж, толилуулсан байна. Мөн хадгаламжийн хүүгийн орлогод 89,376 (2022: 0) мянган төгрөгийн татвар ногдуулж хойшлогдсон татварын зардал ба өглөгөөр бүртгэж, толилуулсан. (Тод.21)

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГҮҮД

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
БДОБҮЦ-ээр хэмжсэн	36,516,662	24,092,178
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн	22,810,574	28,539,594
	59,327,236	52,631,772

¹⁰ 21.1.15- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлого нь татвараас чөлөөлөгдсөн.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл болон бизнес загвар дараах байдалтай байна.

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө		
Эргэлтийн		
Монгол Улсын Засгийн Газрын бонд (ii)	726,477	-
Банкинд байршуулсан хадгаламж (i)	22,084,097	18,340,871
	22,810,574	18,340,871
Эргэлтийн бус		
Монгол Улсын Засгийн Газрын бонд (ii)	-	10,198,723
	-	10,198,723
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө		
Эргэлтийн		
Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй өмчийн хэрэгсэл (iii)	17,947,172	12,607,609
Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй өрийн хэрэгсэл (iv)	18,569,490	8,782,899
	36,516,662	21,390,508
Нийт		
Эргэлтийн бус		
Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй өрийн хэрэгсэл (iv)	-	2,701,670
	-	2,701,670

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл дараах байдалтай байна:

i-Хугацаатай хадгаламж нь Монгол Улсын арилжааны банкуудад байршуулсан жилийн 6-17.5% -ийн хүүтэй, 6-12 сарын хугацаатай хадгаламжуудаас бүрдэнэ. Тайланд онд 1,370,087 (2022: 2,662,056) мянган төгрөгийн хүүгийн орлого олсон байна (Тод.7).

ii- Тус өрийн хэрэгсэл нь Монгол Улсын засгийн газрын 2021 оны 07 сарын 07-нд гаргасан жилийн 8.45 хувийн хүүтэй, хагас жил тутамд хүү төлөгдөх 10 жилийн хугацаатай, нэг бүр нь 100 доллар нийт 213,000 долларын нэрлэсэн үнэтэй, 2,130 ширхэг бондоос бүрдэнэ. Тайлант онд үнэт цааснаас 916,958 (2022: 282,646) мянган төгрөгийн хүүгийн орлого олсон байна (Тод.7).

iii- Өмчийн үнэт цаасанд оруулсан БДОБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд Өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт нь даатгал, худалдаа, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр ложистик, банк санхүүгийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтаас бүрдэх ба нийт 8 компанийн нээлттэй үнэт цаасанд хөрөнгө оруулсан байна. Тайлант онд 718,452 (2022: 37,579) мянган төгрөгийн ногдол ашиг хүлээн авсан байна (Тод.8).

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

iv- Өрийн үнэт цаасанд оруулсан БДОБҮЦ-р хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүд

Сан нь банк, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 6 компанийн 2024-2025 онд дуусах хугацаатай, жилийн 17.5 хувиас 19.6 хувийн хүүтэй, улирал тутам хүүг төлөх нөхцөлт өрийн бичгүүд эзэмшдэг бөгөөд эдгээрээс ямар нэг хугацаа хэтрэлттэй өрийн бичиг байхгүй байна. Тайлант онд тухайн үнэт цааснуудаас 1,873,289 (2022: 1,142,187) мянган төгрөгийн хүүгийн орлого олсон байна (Тод.7).

Санхүүгийн хөрөнгүүдээс үүссэн ашиг алдагдлууд:

	2023.12.31 Мян.төг	2022.12.31 Мян.төг
Хүүгийн орлого		
Хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	2,287,045	2,944,702
БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн хэрэглүүрээс хүлээн авсан хүүгийн орлого	1,873,289	1,142,187
	4,160,334	4,086,889
Ногдол ашиг		
БДОБҮЦ-ээр хэмжсэн өмчийн хэрэглүүрээс хүлээн авсан ногдол ашиг	718,452	37,579
	718,452	37,579
Олз, гарз		
ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ, цэнийн цэвэр өөрчлөлт	-	246,031
БДОБҮЦ-р хэмжсэн өмч, өрийн хэрэглүүрийн арилжааны олз	154,955	-
Хорогдуулсан өргөөр хэмжсэн өрийн хэрэглүүрийн арилжааны олз	489,430	-
БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалд шилжүүлсэн бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	322,998	-
	967,383	246,031
Бусад нөөц		
БДОБҮЦ-ээр хэмжигдэх өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн олз	860,487	95,398
БДОБҮЦ-р хэмжигдэх өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн гарз	(451,122)	1,003,880
	409,365	1,099,278

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

14. ХҮҮГИЙН АВЛАГА

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Монгол Улсын Засгийн Газрын бондын хүүгийн авлага (Тод.13)	15,625	270,171
Харилцах, хадгаламжийн хүүгийн авлага (Тод.13)	893,760	918,218
	909,385	1,188,389

15. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Харилцах данс дахь мөнгөн хөрөнгө	121,584	1,817,900
	121,584	1,817,900

16. САНГИЙН НЭГЖ ЭРХ

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
01 сарын 01-нээр	50,000,000	50,000,000
Гаргасан нэгж эрх	-	-
12 сарын 31-нээр	50,000,000	50,000,000

Сан нь нэг бүр нь нэг мянган (1,000) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт тавин сая ширхэг зарлаж, гаргасан нэгж эрхтэй байна.

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийт 50,000,000 нэгж эрх олон нийтэд санал болгож бүх нэгж эрх төлөгдсөн ба тайлант оны эцэст 8,942 (2022: 8,996) нэгж эрх эзэмшигчид бүртгэлтэй байна. "Мандал Ассет Менежмент" УЦК ХХК нь нийт нэгж эрхийн 5.09 (2022: 5) хувийг буюу хамгийн өндөр хувийг эзэмшиж байна.

17. БУСАД НӨӨЦ

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
01 сарын 01	971,456	-
БДОБҮЦ-ээр хэмжих өрийн болон өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн олз, (гарз)	(239,093)	1,099,278
Бусад дэлгэрэнгүй орлогоос	-	(127,822)
Үүссэн хойшлогдсон татвар	(322,998)	-
Ашиг, алдагдалд тайлагнасан хэрэгжсэн олз	409,365	971,456
12 сарын 31		

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

18. ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
01 сарын 01		
Нэмэгдсэн	3,965,117	(157,352)
12 сарын 31	<u>9,669,518</u>	<u>3,965,117</u>

19. БУСАД ӨГЛӨГ

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
Монголын хөрөнгийн биржтэй холбоотой өглөг	90,096	75,000
Бусад богино хугацаат өр төлбөр	78,351	460,833
12 сарын 31	<u>168,447</u>	<u>535,833</u>

20. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ӨР

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
01 сарын 01		
Тайлант жилийн үр дүнд сууринсан	16,633	46,314
БДОБҮЦ-ээр дамжуулан бүртгэсэн санхүүгийн		
хөрөнгийн хойшлогдсон татварын өр төлбөрөөс	116,062	152,705
тайлант онд хэрэгжсэн дүн	21,323	180,897
Бусдад суутгуулан төлсөн татвар	(116,062)	(274,572)
Төлсөн татвар	(16,457)	(88,711)
12 сарын 31	<u>21,499</u>	<u>16,633</u>

21. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
01 сарын 01		
Тайлант онд үүссэн	213,238	53,074
Хэрэгжсэн	89,376	213,238
Ашиг алдагдалд шилжүүлсэн татварын чөлөөлөлт	-	(53,074)
(Тод.10)	(213,238)	-
12 сарын 31	<u>89,376</u>	<u>213,238</u>

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

22. ХОЛБООТОЙ ТАЛУУД

Холбоотой талуудын нэр	Харьяалал	Хамаарал
Хуулийн этгээд		
Мандал санхүүгийн нэгдэл ХХК	МУ-ын хуулийн этгээд	ХОМК-ийн толгой компани
Мандал Ассет Менежмент УЦК ХХК	МУ-ын хуулийн этгээд	ХОМК
Мандал капитал маркетс УЦК ХХК	МУ-ын хуулийн этгээд	Толгой компанийн эзэмшдэг хараат компани
Мандал даатгал ХК	МУ-ын хуулийн этгээд	Эцсийн өмчлөгчийн хувь оролцоотой компани
Тэнгэр даатгал ХХК	МУ-ын хуулийн этгээд	Толгой компанийн эзэмшдэг хараат компани
ТУЗ-ийн гишүүд		
Р.Амаржаргал	МУ-ын иргэн	ТУЗ-ийн дарга
Н.Монсor	МУ-ын иргэн	Гишүүн
Ч.Анхбаяр	МУ-ын иргэн	Гишүүн
Ц.Батсүх	МУ-ын иргэн	Гишүүн
Г.Батзориг	МУ-ын иргэн	Гишүүн
Хувь хүн		
Ө.Ганзориг	МУ-ын иргэн	Эцсийн өмчлөгч
Г.Ганзориг	МУ-ын иргэн	Гүйцэтгэх захирал

Холбоотой талын мэдээллийг удирдлагын бэлтгэсэн мэдээлэл болон олон нийтэд нээлттэй мэдээлэлд тулгуурлан бэлтгэсэн бөгөөд тодруулагдаагүй холбоотой тал байж болзошгүй.

Холбоотой талуудын эзэмшиж байгаа нэгж эрхийн тоо хэмжээ болон нэгж эрхэд эзлэх хувийг харуулбал:

Холбоотой талууд	2023.12.31		2022.12.31	
	Тоо ширхэг	Хувь	Тоо ширхэг	Хувь
Мандал капитал маркетс УЦК ХХК	386,673	1%	228,274	0.5%
Мандал ассет менежмент УЦК ХХК	2,546,682	5%	2,500,000	5%
Мандал даатгал ХК	492,112	1%	-	-
Тэнгэр даатгал ХХК	1,462,170	3%	-	-
	4,887,637	10%	2,728,274	5.5%

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

22. ХОЛБООТОЙ ТАЛУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талын дансны үлдэгдлийг тодруулбал:

	2023.12.31	2022.12.31
	Мян.төг	Мян.төг
ХОМК-ийн үйлчилгээний зардал (Тод.11)	49,185	172,650
ХОМК-ийн урамшуулал (Тод.11)	-	421,006
	49,185	593,656

23. ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН НИЙЦЭЛ

Санхүүгийн Зохицуулах Хорооны 275 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын хүрээнд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцаанд оруулах хөрөнгийн нийт хэмжээ нь сангийн нийт активын 70 хувиас хэтрэхгүй байх ёстой гэж заасан ба тайлант онд тухайн хувь 30.25 (2022: 22.63) хувь буюу тухайн шаардлагыг хангаж ажилласан байна. Мөн 32.52 (2022: 38.93) хувийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэлд, 37.23 (2022: 36.19) хувийг мөнгөн хөрөнгөд байршуулсан байна.

24. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Монголын Хөрөнгийн Бирж ХК (цаашид "МХБ ХК" гэх) нь 2021 оны 08 сард сангийн нэгж эрхийг бүртгэж, татан төвлөрүүлсэн хөрөнгийн 1 хувьтай тэнцэх үйлчилгээний хураамж 500,000 мянган төгрөгийг нэхэмжилсэн.

Сан нь үйлчилгээний хөлсийг 1 хувиар тогтоосон нь хөрөнгө оруулагчдад санхүүгийн дарамт үүсгэж, сангийн зардлыг ихээр нэмэгдүүлж байгаа ба хуучин хэрэгжиж байсан журам нь шударга бус нөхцөлтэй гэж үзээд үйлчилгээний төлбөрийг төлөхөөс татгалзаж шүүхэд хандсан.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх нь 2023.01.24-ний өдрийн 92 дугаар шийдвэрээр МХБ ХК-ийн ТУЗ-ийн 2021.12.30-ны өдрийн 16 тоот тогтоолоор баталсан "Хамтын, хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д өөрчлөлт оруулсан үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээгээр 125,000 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс төлөх шийдвэр гарсан байна.

Үүний дагуу сан нь 125,000 мянган төгрөгийн үйлчилгээний шимтгэлийг зардлаар хүлээн зөвшөөрч 50,000 мянган төгрөгийг төлсөн. Тайлант оны эцэст 75,000 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

**МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

24. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

МХБ ХК нь анхан шатны шүүхийн шийдвэрийг үл хүлээн зөвшөөрч, талууд дахин маргалдсанаар захиргааны хэргийн анхан шатны шүүх, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүд гарсан боловч Сан нь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд уг маргаантай холбоотой холбогдогч нарыг дахин тогтоолгоо хандсан.

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нь 2023.12.28-нд захиргааны хэрэг үүсгэх тухай 128/ШЗ2024/0213 тоот захирамж гаргасан учир үйлчилгээний шимтгэлтэй холбоотой маргааныг эцэслэн шийдвэрлэгдсэн гэж үзээгүй бөгөөд үлдэгдэл төлбөрийг төлөхгүй байх үндэслэлтэй гэж үзээд өр төлбөр үүсгэн бүртгээгүй байна.

Аудитын явцад МХБ ХК нь Сангаас 450,000 мянган төгрөгийн авлагатай гэж тулган баталгаажуулалтын хариуг ирүүлсэн ба дараагийн тайлант жилд зарга маргааны шийдвэрлэгдсэн байдлаас хамааран өр төлбөр, ашиг алдагдлыг дахин тохируулах өндөр магадлалтай байна.

25. ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024.02.19-ний өдрийн 01 тоот тогтоолоор “Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС” ХХК-ийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.